

2014 ОНЫ 9 ДҮГЭЭР САРЫН ДААТГАЛЫН МЭДЭЭ

2014 оны 10 дугаар сарын 17

1. ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧДИЙН МЭДЭЭЛЭЛ:

2014 оны 9 дүгээр сарын байдлаар даатгалын салбарт үйл ажиллагаа явуулж буй тусгай зөвшөөрөл, эрх эзэмшигчдийн бүртгэлд дараах өөрчлөлт орсон байна.

/тоогоор/

№	Тусгай зөвшөөрөл эзэмшигчид	2014.09.01	Нэмэгдсэн	Хасагдсан	2014.09.30
1	Даатгалын компани	17			17
2	Даатгалын компанийн салбар	254			254
3	Даатгалын компанийн төлөөлөгчийн газар	7	1 ¹		8
4	Даатгалын зуучлагч	26			26
5	Даатгалын зуучлагч компанийн салбар	78			78
6	Даатгалын хохирол үнэлэгч	19			19
7	Даатгалын хохирол үнэлэгч компанийн салбар	18	4 ²		22
8	Даатгалын төлөөлөгч	3423	8 ³		3431
9	Актуарч	15			15
10	Жолоочийн даатгалын зөвшөөрөл	16			16

¹Хорооны даргын 2014 оны 9 дүгээр сарын 10-ны өдрийн 248 дугаар тушаалаар “Мөнх даатгал” ХХК-д Монгол Улсаас БНХАУ-ын Эрээн хотод суугаа Ерөнхий консулын газрын байранд төлөөлөгчийн газар нээн ажиллуулахыг зөвшөөрсөн байна.

²Хорооны даргын 2014 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн 240 дүгээр тушаалаар “Сэлэнгэ эстимэйт” ХХК-д Улаанбаатар хотын Багануур дүүрэгт, Хорооны 2014 оны 09 дүгээр сарын 10-ны өдөр 247 дугаар тогтоолоор “Лэндс” ХХК-д Нийслэлийн Хан-Уул, Чингэлтэй дүүрэгт, Хорооны 2014 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн 270 дугаар тушаалаар “Итгэлт эстимэйт” ХХК-д Баянгол дүүргийн нутаг дэвсгэрт салбар нээн ажиллуулахыг зөвшөөрсөн байна.

³Хорооны даргын 2014 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн 257 дугаар тушаалаар “Тэнгэр даатгал” ХХК-ийн 8 иргэнд даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон байна.

2. САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ:

Даатгалын байгууллагуудын 2014 оны 09 дүгээр сарын даатгалын үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтүүдийг сарын болон өссөн дүнгээр харуулбал дараах байдалтай байна.

Ердийн даатгалын компаниудын хувьд :

/төгрөгөөр/

Үзүүлэлт	2014.09.30 /сарын дүн/	2014.09.30 /өссөн дүн/
Даатгалын нийт хураамж	7 993 596 769,55	74 864 656 330,32
Үүнээс: Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын хураамж	1 162 890 920,31	14 102 028 938,95
Олгосон нийт нөхөн төлбөр	3 005 769 277,23	22 974 616 480,31
Үүнээс: Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын нөхөн төлбөр	1 175 888 220,72	9 115 825 654,93
Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын нөхөн төлбөр авсан даатгуулагчийн тоо	2 259,00	21 046,00
Давхар даатгалд төлсөн хураамж	2 229 090 540,50	29 122 806 444,18
Байгуулсан даатгалын гэрээний тоо	69 042,00	853 758,00
Үүнээс: Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын гэрээний тоо	27 692,00	310 199,00
Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд хамрагдсан даатгуулагчийн тоо	29 882,00	381 357,00
Даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн	555 987 000 000,00	555 987 000 000,00
Хамгийн их дүнтэй нөхөн төлбөр	130 564 239,44	145 933 562,17

2014 оны 9 дүгээр сарын байдлаар /өссөн дүнгээр/ даатгалын хураамжийн орлого 74864.6 сая төгрөг, үүнээс жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын хураамж 14102.0 сая төгрөг, олгосон нөхөн төлбөр 22974.6 сая төгрөг ба үүнээс жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын нөхөн төлбөр 9115.8 сая төгрөг болсон байна. Эндээс даатгалын хохирлын харьцаа өссөн дүнгээр 31.0 хувь болсон бөгөөд сарын дүнгээр 38.0 хувь байна.

Өмнөх оны мөн үетэй /сарын дүнгээр/ дээрх үзүүлэлтүүдийг харьцуулахад даатгалын хураамжийн орлого 1271.6 сая төгрөгөөр буюу 1.16 дахин буурч, жолоочийн хариуцлагын даатгал 116.8 сая төгрөгөөр буюу 1.1 дахин, олгосон нөхөн төлбөр 888.9 сая төгрөгөөр буюу 1.4 дахин, жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын нөхөн төлбөр 941.0 сая төгрөгөөр буюу 1.3 дахин тус тус нэмэгдсэн байна.

Ердийн даатгалын компаниудын 2014 оны 09 дүгээр сард байгуулсан даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр даатгалын үнэлгээ бүхий гэрээ нь “Мандал женерал даатгал” ХХК-ийн даатгалын 555.9 тэрбум төгрөгийн үнэлгээтэй гэрээ юм. Мөн хамгийн өндөр дүнтэй нөхөн төлбөрийг “Монгол даатгал” ХХК 130.5 сая төгрөгийг олгосон байна.

Урт хугацааны даатгалын компанийн хувьд :

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	2014/09/30 сарын дүн	2014/09/30 өссөн дүн
Даатгалын нийт хураамж	28 846 203,00	1 016 581 352,38
Олгосон нийт нөхөн төлбөр	28 026 851,00	349 766 088,00
Давхар даатгалд төлсөн хураамж	1 912 623,00	17 875 331,00

Байгуулсан даатгалын гэрээний тоо	16,00	221,00
Насан туршийн даатгал	5,00	14,00
Эрүүл мэндийн даатгалд	3,00	15,00
Сургалтын төлбөрийн хуримтлалын даатгалд	0,00	14,00
Тэтгэврийн даатгалд	0,00	6,00
Орон сууцны даатгалд	1,00	2,00
Хуримтлалын даатгалд	1,00	2,00
Зээлдэгчийн амь насны даатгалд	6,00	168,00
Даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээтэй гэрээ	0,00	11,00
Даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн	450 000 000,00	3 495 000 000,00
Хамгийн их дүнтэй нөхөн төлбөрийн дүн	0,00	0,00

Урт хугацааны даатгагч 2014 оны 09 дүгээр сарын байдлаар өссөн дүнгээр 1016.6 сая төгрөгийн даатгалын хураамжийн орлоготой байгаа бөгөөд өмнөх оны мөн үеийнхээс 333.4 сая төгрөгөөр буюу 1.5 дахин, нөхөн төлбөр 212.6 сая төгрөгөөр буюу 2.5 дахин нэмэгдсэн байна. Даатгалын хохирлын харьцаа 34.4 хувьтай байна.

Даатгалын зуучлагч компаниудын хувьд :

Үзүүлэлт	/төгрөгөөр/	
	2014.09.30 /сарын дүн/	2014.09.30 /өссөн дүн/
Нийт орлого	29 649 120 116,34	681 711 464 002,12
Даатгалын зуучлагчийн орлого	308 106 118,02	2 364 500 527,87
Үүнээс: Сайн дурын даатгал	152 895 580,32	1 094 099 012,37
Албан журмын даатгал	158 260 537,70	1 258 482 340,41
Даатгуулагчаас зуучлагчаар дамжин төлсөн даатгалын хураамж	711 282 259,06	5 947 263 180,15
Зуучилсан даатгалын гэрээний тоо	21 551,00	138 694,00
Зуучилсан даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээ	95 622 800 000,00	343 159 668 060,00

2014 оны 09 дүгээр сарын байдлаар даатгалын зуучлагч компаниуд / өссөн дүнгээр/ 2364.5 сая төгрөг, /сарын дүнгээр/ 308.1 сая төгрөгийн даатгалын зуучлалын орлоготой ажилласан байна. Үүний 49.5 хувийг сайн дурын даатгалаас үлдсэн хувийг албан журмын даатгалын хураамжийн орлогоос бүрдүүлсэн байна. “Ренессанс групп” ХХК хамгийн өндөр үнэлгээтэй буюу 95.6 тэрбум төгрөгийн даатгалын гэрээг зуучилсан байна.

Даатгалын зуучлагч компаниудаас “Хас банк” ХХК, “Аме” ХХК, “Монголиан интернэшнл” ХХК, “Эс ай би эс” ХХК, “Эм жи ай би” ХХК, “Юу ай би” ХХК-иуд тус тус орлогогүй ажилласан байна.

Даатгалын хохирол үнэлэгч компаниудын хувьд :

Үзүүлэлт	2014.09.30 /сарын дүн/	2014.09.30 /өссөн дүн/
Нийт орлого	89 016 773,01	673 349 108,22
Даатгалын хохирол үнэлгээний орлого	50 147 216,64	359 983 482,98
Үүнээс: Сайн дурын даатгал	18 305 336,64	111 637 411,19
Албан журмын даатгал	37 938 880,00	253 042 571,79
Үнэлсэн даатгалын хохирлын тоо	2 306,00	17 518,00
Үнэлсэн даатгалын хохирлоос хамгийн өндөр хохирлын дүн	85 773 500,00	85 773 500,00

2014 оны 09 дүгээр сарын байдлаар /өссөн дүнгээр/ даатгалын хохирол үнэлэгч компаниуд 359.9 сая төгрөгийн хохирол үнэлгээний орлоготой ажилласан байна. Үүнээс 31.0 хувийг сайн дурын, үлдсэн хувийг албан журмын даатгалын хохирлын үнэлгээний орлогоос төвлөрүүлсэн байна.

“Итгэлт эстимэйт” ХХК нь даатгалын хохирлоос хамгийн өндөр хохирлын дүн болох 85.7 сая төгрөгийн үнэлгээг хийсэн байна.

Бусад

Хорооны 2014 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн 250 дугаар тушаалаар “Жи эй си си” ХХК-д хувьцаа эзэмшигчдийн бүтэцдээ өөрчлөлт оруулахыг зөвшөөрөх тухай, Хорооны 2014 оны 9 дүгээр сарын 12-ны өдрийн 254 дүгээр тушаалаар “Си эн эн икс” ХХК-ийн дүрмийн сангийн бүтэцэд өөрчлөлт оруулахыг тус тус зөвшөөрсөн байна.

ДААТГАЛЫН ГАЗРЫН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТЭС